



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 11 САР | ДУГААР 72

## ГАРЧИГ



2–3 Бодлогын нийтлэл

6–9 Зохицуулалтын мэдээ

10–11 Онцлох булан

12–14 Тогтвортой санхүүжилт

15 Компанийн засаглал, комплайнс

16–17 Финтек ба регтек

18–23 Судлаачийн индэр

24–25 Хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэл гэж юу вэ?

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## “СИНГАПУР ФИНТЕК ФЕСТИВАЛЬ–2024”–ААС ОНЦЛОХ НЬ

### “СИНГАПУР ФИНТЕК ФЕСТИВАЛЬ–2024”–С ОНЦЛОХ НЬ


Санхүү, технологийн салбарын шинийг санаачлагч, тэргүүлэгчид, бодлого боловсруулагчид болон хөрөнгө оруулагчид цуглан санхүүгийн салбарын ирээдүйг тодорхойлох технологийн шийдэл, инновацыг танилцуулан, хэлэлцэж хамтын ажиллагааны суурийг тавьдаг “Сингапурын Финтек Фестиваль” энэ жил зүүн өмнөд Азийн санхүүгийн төв болох Сингапур Улсад 2024 оны 11 дүгээр сарын 06–08–ны өдрүүдэд 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

“Сингапурын Финтек Фестиваль”–ийг Сингапурын Төв банк 2016 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж буй бөгөөд энэ жилийн фестивалд 134 орны 65,000 гаруй оролцогчид оролцон нийт 400 гаруй хэлэлцүүлэг, семинар, арга хэмжээ, 600 гаруй санхүү, технологийн компаниудын үзэсгэлэн, 41 олон улсын үзэсгэлэнгийн танхимыг танилцуулсан том арга хэмжээ боллоо. Энэ удаагийн фестиваль нь санхүү, технологийн салбарын хамгийн сүүлийн үеийн сэдвүүд болох хиймэл оюун ухаан, квантум тооцоолол, дижитал хөрөнгө, төлбөр тооцооны шинэ эрин үе болон санхүүгийн хүртээмж зэрэг голлох сэдвүүдийг хамарлаа. Ингээд дэлхийн хамгийн том финтек фестиваль болох “Сингапур Финтек Фестиваль–2024”–ийн үеэр өрнөсөн онцлох 5 үйл явдлыг тоймлон хүргэе.

### 1. ФЕСТИВАЛИЙН ГОЛЛОХ СЭДВҮҮДИЙН НЭГЭЭР САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ КВАНТУМ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭГ ОНЦЛОН ХЭЛЭЛЦЛЭЭ.



“Сингапурын Финтек Фестиваль–2024” нь (1) хиймэл оюун ухаан болон квантум технологийг ашиглах замын зураг; (2) цахим хөрөнгийг ашиглах, хөгжүүлэх ажлын төлөвлөгөө; (3) шинэ үеийн төлбөр тооцооны систем, хил дамнанасан төлбөрийн шийдэл; (4) тогтвортой хөгжлийг бодит үйл хэрэг болгох; (5) санхүүгийн хүртээмж, санхүүгийн эрүүл мэндийг нэмэгдүүлэх (6) санхүүгийн салбар дахь карьерын хөгжил болон ирээдүй гэсэн үндсэн 6 сэдвийн дор 400 гаруй хэлэлцүүлгийг 900 орчим зочин илтгэгчтэйгээр зохион байгууллаа.



### ЗАСГИЙН ГАЗРЫН ТАНХИМ

Ерөнхий сайдын тэргүүлсэн, Засгийн газрын бодлогын шийдвэрийг гаргадаг сайд нарын хамтын байгууллага. Энэ нь төр засгийн гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэр гаргах хамгийн дээд байгууллага юм. Засгийн газрын хуралдааны хөтөлбөрийг ерөнхий сайдын алба (манайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар) гаргаж ерөнхий сайд баталдаг. Танхимын хамтын шийдвэр болон тэдний нэрийн өмнөөс гаргасан аливаа шийдвэр, санал болгосон арга хэмжээний төлөө танхимын гишүүд хамтын болон хувийн хариуцлага хүлээдэг. Танхимын шийдвэрийг сайд нар хариуцсан яам, агентлагаар дамжуулан хэрэгжүүлдэг.



### CABINET

Collective of ministers chaired by the Prime Minister that makes government policy decisions. It is the top-decision making body in the executive arm of government. The agenda for the Cabinet meetings is prepared by the Office of the Prime Minister and approved by the Prime Minister. Members of Cabinet take collective and individual responsibility for their joint decisions, as well as for the decisions that are taken in their name and the measures that they propose. Cabinet decisions are implemented by ministers through departments or other agencies for which they are responsible.

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### 2021–2024 ОНД ДААТГАЛЫН САЛБАРТ ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХӨРӨНГӨ:** Даатгагчийн төлбөрийн чадварын тооцооллыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн сайжруулж, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор тогтмол хувь, хязгаарлалт, дүрэмд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлал руу шилжүүлэх зохицуулалтыг тусгасан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг Хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор шинэчлэн батлаад байна. Энэхүү журам, заавар хэрэгжиж эхэлснээр даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй, нээлттэй, ил тод болохын зэрэгцээ даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан таних, түүнээс сэргийлэх систем нэвтрэх, улмаар салбарын засаглал сайжирч, тогтвортой байдал хангагдах, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын даатгалд итгэх итгэл нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

**ДААТГАГЧИЙН БАТАЛГАА:** Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сард Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад даатгагч нь баталгаа, батлан даалт гаргах боломжийг бүрдүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулснаар төрийн худалдан авах ажиллагаанд даатгагчийн баталгааг хүлээн авах, орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг даатгагчийн баталгаагаар шийдвэрлэх боломжтой болсон. Үүний дагуу тус Хороо хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хорооны 2023 оны 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Одоогийн байдлаар даатгалын компаниуд 16.9 тэрбум төгрөгийн баталгаа гаргаад байна.

**ДААТГАЛЫН БОЛОВСРОЛ:** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13-т “иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу тус Хорооны даргын тушаалаар олон нийтийн даатгалын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулахтай холбоотой судалгаа хийх, санал дүгнэлт гаргах болон олон нийтэд даатгалын ач тусыг таниулах, зөв ойлголт, мэдлэг, мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг даатгалын салбарын бүх оролцогчдын төлөөллийг хамарсан бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулан, /дигитал галерей-оюутан сурагчдыг хамруулсан зэргийг дурдвал/ арга хэмжээг хамтран хэрэгжүүлж ажиллаж байна.

**БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ШААРДЛАГУУДЫГ ХЯЛБАРШУУЛАВ:** Хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” журамд өөрчлөлт оруулж, даатгалын бүртгэл, зөвшөөрлийг хөнгөвчлөх,

хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах зохицуулалтын орчныг бүрдүүлснээр, хүсэлтийг 100% цахимаар хүлээн авч, хүсэлт шийдвэрлэх хугацаа 3.9 дахин буурсан байна.

**ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ:** Хорооны 2024 оны 526 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” журамд ипотекийн даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, холбогдох зохицуулалтыг шинэчлэн тусгалаа. Энэхүү шинэчлэлээр ипотекийн зээлдэгчийн амь насны даатгалыг зөвхөн урт хугацааны даатгагч хийж гүйцэтгэх буюу даатгуулагч аливаа шалтгааны улмаас амь насаа алдах эрсдэлээс хамгаалагдах болсноор даатгалын хамгаалалтын хэмжээ ердийн даатгалын компанийн санал болгож байсан хамгаалалтаас 9.6 дахин их болж, ипотекийн даатгалын үйл ажиллагаа олон улсын жишгийн дагуу даатгуулагчдын хэрэгцээ шаардлагад зохих түвшинд нийцсэн байдлаар хэрэгжих, даатгалын гэрээний сунгалтын асуудал шийдвэрлэгдсэнээр даатгалын хамрагдалт нэмэгдэх, ипотекийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан бүрдэх зэрэг үр дүн, ач холбогдлыг бий болгох юм.

**ЖОЛООЧИЙГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ – ДААТГАЛЫН ИТГЭЛЦҮҮР:** Жолоочийн даатгалын тухай хууль 2012 оноос хэрэгжиж эхэлснээс хойш анх удаа тус Хорооны 2024 оны 493 дугаар тогтоолоор “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг шинэчлэн баталж, даатгалын хураамжийн хэмжээг тогтоох итгэлцүүрүүдийн хамаарлыг өргөтгөх замаар эрсдэлийг илүү нарийвчилсан, бодитой тооцох, жолоочийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтын орчныг бий болгосон.

**ЗААВАЛ ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ:** Салбар бүрийн эрсдэлийн онцлогоос шалтгаалан заавал шилжүүлэх эрсдэлийг тодорхой болгож, заавал даатгалын нэгдсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэхээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, зохицуулалтын орчныг бүрдүүлж эхэлсэн. Тухайлбал, Аялал жуулчлалын тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль гэх мэт...

**ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ, НОГООН ДААТГАЛ:** Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх

үзүүлэлт” журамд Хорооны 2022 оны 129 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж, “ногоон даатгал”-тай холбоотой зохицуулалтуудыг нэмж тусгасан. Ингэснээр “ногоон даатгал”-ын бүтээгдэхүүнийг тусад нь бүртгэх, даатгалын компаниудад “ногоон бонд”-д хөрөнгө оруулах нөхцөл бүрдэж байна. Түүнчлэн “ногоон санхүүжилт”-ийн эко системийг бүрдүүлэхэд даатгалын салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломжтой болсон.

**ДААТГАГЧДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО:** Даатгалын компанийн үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахтай холбоотойгоор тэдгээрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хууль журмын хүрээнд тодорхой хязгаарлалт, шаардлагуудыг тавьдаг бөгөөд энэ хүрээнд тус Хорооноос хөрөнгийн зах зээлийг дэмжих, нөгөөтээгүүр даатгагчийн хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, 4 дүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-уудад дээр дурдсан шаардлага, олон улсын жишгийн дагуу хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Ингэснээр даатгагчийн хөрөнгө оруулалтын багцад томоохон өөрчлөлт орж, даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулах хөрөнгө оруулалт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 101.7 тэрбум төгрөг болоод байна. Мөн түүнчлэн 2018 онд даатгалын салбарын анхны IPO Хөрөнгийн бирж дээр гарсан бөгөөд одоогоор 5 даатгалын компани хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй компаниуд болов.

#### **“ДААТГАЛ–НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ДАРХЛАА” БОДЛОГЫН ФОРУМ**

Даатгалын салбарын 90 жилийн ойг тохиолдуулан Санхүүгийн зохицуулах хороо салбарын мэргэжлийн холбоодтой хамтран Даатгалын салбарын нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөг нэмэгдүүлэх талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх, улмаар хэлэлцүүлгээс гарсан үр дүнд үндэслэн зохицуулалтын болон зах зээлийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлох зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 21–ний өдөр “Даатгал–нийгэм эдийн засгийн дархлаа” бодлогын форумыг зохион байгууллаа.

Форумын үеэр “Салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл”, “Бизнесийн орчинд нөлөөлж буй хүчин зүйл”,



“Даатгалын салбарын хүртээмжийг тэлэх боломж” гэсэн 3 үндсэн сэдвийн хүрээнд дараах онцлог, шийдэл бүхий илтгэлүүдийг тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Үүнд:

### 1. Салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл

Энэхүү илтгэлүүдийн хүрээнд сүүлийн 20 жилийн хугацаанд даатгалын салбарт гарсан ололт амжилт, түүнд нөлөөлсөн бодлогын арга хэмжээнүүд болон салбарын хөгжлийн үзүүлэлтүүд олон улсын дунджаас доогуур байгаа талаар, мөн даатгалын салбар нь дархлаатай Монгол Улс байх түлхүүр шийдэл, банкнаас хараат санхүүгийн салбарыг эрүүл, хямд тэнцвэртэй санхүүжилтээр тэтгэх гарц буюу мэргэжлийн хөрөнгө оруулагч бөгөөд тогтвортой хөгжлийн тэтгэгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах шийдэл нь даатгалын салбар болохыг тус тус онцлон тэмдэглэлээ. Үүний зэрэгцээ салбарт тулгамдаж буй асуудлууд, Даатгалын багц хуулийн шинэчлэл, Гамшгийн даатгалын тухай хуулийг баталж мөрдүүлэх, хариуцлагын даатгалын тогтолцоогоор дамжуулан стандарт мөрдүүлэх, инсуртек, хөрөнгийн зах зээлд үзүүлэх эерэг нөлөөлөл, олон улсын чиг хандлагын талаар танилцуулагдаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

### 2. Бизнесийн орчинд нөлөөлж буй хүчин зүйлс

Энэхүү илтгэлүүдийн хүрээнд урт хугацааны даатгагчид хөрөнгө оруулалт хийсэн туршлага, даатгалын салбарт

хөрөнгө оруулалт хийх үндэслэл, нийгэм эдийн засагт гүйцэтгэх оролцоо, салбарын зарим хууль тогтоомжид хийсэн системийн шинжилгээ, даатгалын компанийн засаглалын үүрэг оролцоо, ёс зүйн асуудал, сайжруулах арга замуудын талаар танилцуулагдлаа. Түүнчлэн даатгалын зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх дотоод хүчин зүйл буюу даатгагч нараас хамаарсан үйл ажиллагааны зардлыг бууруулах, дижитал шилжилт, технологийн боломжууд, Байгаль орчин нийгэм засаглал, даатгалын 7 зарчмын ойлголтыг даатгуулагч, хэрэглэгчдэд ойлгуулах асуудал, мөн гадаад хүчин зүйл буюу даатгагчдаас бусад зохицуулагч байгууллага, судлаачид болон бусад этгээдээс хамаарсан заавал даатгалын хэлбэрийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг зохистой түвшинд барих, даатгалын нийгэм эдийн засгийн хөшүүргийн үр нөлөөг нэмэгдүүлэх, эдгээрт тулгуурлан цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, холбогдох хэлэлцүүлгийг өрнүүлэв.

### 3. Даатгалын салбарын хүртээмжийг тэлэх боломж

Эдгээр сэдвүүдийн хүрээнд ерөнхий боловсролын болон их дээд сургуульд суралцагчид, олон нийтийн дундаас түүвэрчилсэн байдлаар судалгаа авч тэдгээрийн эрсдэл болон даатгалын талаарх ойлголт, даатгалын хэрэгцээ шаардлага, олон нийтийн даатгалын боловсролын асуудал, мөн жолоочийн даатгал ба зам тээврийн ослыг бууруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх боломж, эрдэс баялгийн салбар гэх мэт томоохон салбарын эрсдэлийг даатгахад даатгагчдын хамтын сан байгуулах, нэгдсэн платформ бий болгох, даатгагчийн баталгаа нэвтрүүлж буй туршлагын талаар ярилцаад, эцэст нь даатгалын салбарын үйлчилгээ буюу даатгагч нарын борлуулалт суурьтай бус андеррайтинг эрсдэлийн удирдлагад суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, нөхөн төлбөр олгох үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын оролцоог багасгах, зуучлагч болон хохирол үнэлэгчдийн хувьд олон төрлийн даатгалын хэлбэрийн бүтээгдэхүүнтэй ажиллах байдлаар мэргэжлийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, зохицуулагч байгууллагын хувьд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр илүү боловсронгуй, даатгалын зарчимд нийцсэн байдлаар хууль тогтоомж боловсруулах талаар танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.



Энэхүү форумын үр дүнд даатгалын салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдгийг онцлохоос гадна 2025–2026 онд хийж хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

**1 дүгээрт,**

салбар бүрд хяналт хариуцлага, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд даатгалын салбарын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тухайн мэргэжлийн оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлгийг ойрын хугацаанд зохион байгуулах;

**2 дугаарт,**

даатгалын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтыг байнгын тогтмол зохион байгуулах мэргэжлийн институтийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

**3 дугаарт,**

даатгалын салбарын мэдээллийн үнэ цэнэ, чанар, хүртээмжтэй байдлыг бий болгож, даатгалын мэдээллийн санг төрийн болон бизнесийн байгууллагуудад ашиглуулах, хурдан шуурхай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

**4 дүгээрт,**

даатгалын компаниуд томоохон эрсдэлүүдийг хамтын даатгалаар даатгах, дотоодын давхар даатгалын компанид тодорхой эрсдэлийг шилжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

**5 дугаарт,**

Ногоон, тогтвортой хөгжлийг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тогтвортой байдлын тайлагналыг салбарт бүрэн нэвтрүүлэх замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх;

**6 дугаарт,**

харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг бий болгож, даатгуулагч харилцагч нарт эерэг мэдрэмж төрүүлэх, даатгалд итгэл итгэлийг дэмжин, сайжруулах чиглэлээр харилцан уялдаатай ажиллах.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### Д.БАЯРСАЙХАН: УУР АМЬСГАЛЫН БОЛОН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СЭДЭВЧИЛСЭН ӨРИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙГ ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРНА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй “Монгол Улс–Ногоон хөгжлийг санхүүжүүлэх нь” сэдэвт форум Төрийн ордонд боллоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Монгол дахь НҮБ, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагын хүрээнд болж буй форумын үеэр эрчим хүчний реформ–Ногоон эрчим хүч, “Уур амьсгалын өөрчлөлт ба ногоон шилжилт”, үндэсний орон сууцжуулалтын санхүүгийн тогтолцоо сэдвийн хүрээнд илтгэл тавихын зэрэгцээ ногоон санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлэх нь, тогтвортой хөдөө аж ахуйн шилжилтийн санхүүжилт зэрэг сэдвийн хүрээнд бодлогын хэлэлцүүлгүүд болсон юм.

Хувийн хэвшил тэр дундаа санхүүгийн салбар олон улсын хөрөнгө оруулагчдаас ихээхэн хэмжээний ногоон, тогтвортой санхүүжилтийг амжилттай татаж, улс орны тогтвортой хөгжлийн

зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй. Гэсэн ч эдгээр эх үүсвэрийг үр дүнтэй хуваарилахад тодорхой бэрхшээлтэй тулгарсан хэвээр байгаа тул ногоон, тогтвортой санхүүжилтийг үр дүнтэй ашиглахтай холбоотой тулгамдсан асуудал, боломж шийдлүүдийн талаар “Ногоон санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлэх нь” хэлэлцүүлгээр хөндсөн юм. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр “Санхүүгийн зохицуулах хороо ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэхэд анхаарч, ногоон болон нийгмийн шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүнийг бодлогоор дэмжиж ирсэн. Тухайлбал, олон нийтэд санал болгон компанийн бонд гаргах ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулж, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах зохицуулалтын орчныг боловсронгуй болгосон нь хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа олон улсын жишигт нийцсэн “Ногоон бонд” гаргах боломж бүрдсэн. Үүний үр дүнд Монгол Улсад болон олон улсын зах зээлд ногоон бондыг амжилттай гаргах үйл ажиллагаа өрнөж байна. Мөн цаашид уур амьсгалын болон тогтвортой байдлын сэдэвчилсэн өрийн хэрэгслүүдийг дотоодын зах зээлд нэвтрүүлэхэд онцгой анхаарна. Нийгмийн сайн сайхныг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тогтвортой шилжилтийн бонд, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилготой бонд, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах гамшгийн бонд, жендэр бонд зэрэг шинэлэг өрийн хэрэгслүүдийг гаргах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг татах өндөр боломжтой. Эдгээр сэдэвчилсэн өрийн хэрэгслүүдийг дотоодын зах зээлд нэвтрүүлэхийн тулд бид зохицуулалтын орчныг сайжруулах, мэдээллийн түвшинг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллана. Мөн салбар бүрийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой шилжилтийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, тайлагналын системийг сайжруулахад анхаарахын зэрэгцээ ногоон төслүүдийг үнэлэх, баталгаажуулах нэгдсэн тогтолцоог бий болгох чиглэлд төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана” гэдгийг онцолсон юм.

Форумын үеэр мөн Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан, Монголын Тогтвортой санхүүжилтийн холбооны удирдах зөвлөлийн дарга Р.Мөнхтуяа нар хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэв. Уг санамж бичгийн хүрээнд БОНЗ, тогтвортой байдлын тайлагналыг системийн тусламжтайгаар компаниуд илүү боловсронгуй, хялбараар тайлагнах боломж бүрдэх төдийгүй БОНЗ–ын дата мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, олон нийтэд мэдээлэхэд илүү хялбар юм.

## ТОГТВОРТОЙ, НОГООН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖУУДЫГ ХЭЛЭЛЦЭВ



“Монголын тогтвортой санхүүгийн форум 2024” гурав дахь өдрөө ШангриЛа зочид буудалд үргэлжилж, эхний салбар арга хэмжээ нь “Нөлөөллийн хөрөнгө оруулалт ба тогтвортой санхүүжилтийн хүртээмжворкшоп” байв. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж “Дэлхий нийтээрээ байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн шударга ёсыг хангах, эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хадгалах гэсэн гурван чухал зорилтын өмнө ирээд байна. Үүнд хүрэхэд хөрөнгө оруулалт, санхүүгийн системийн үүрэг хариуцлага онцгой чухал. Тэр дундаа нөлөөллийн хөрөнгө оруулалт болон тогтвортой санхүүжилт нь зөвхөн санхүүгийн үр ашиг бус, нийгмийн зэрэг өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах зэрэг олон талт үнэт зүйлсийг бий болгож, эрүүл мэнд, боловсрол, сэргээгдэх эрчим хүч, цэвэр ус, хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжлийг дэмжих орчны хамгаалал зэрэг олон салбарт хийгддэгээрээ ач холбогдолтой. Монгол Улс ногоон таксономи, тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи, тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг зэрэг бодлогын томоохон баримт бичгүүдийг баталснаар бүс нутгийн хэмжээнд аливаа санхүүжилт, хөрөнгө оруулалтын урсгалын тогтвортой хөгжлийн зорилтод оруулж буй хувь нэмрийг бүртгэх, тайлагнах, дотоодын болон гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Санхүүгийн зохицуулах хороо ч урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон бүтээгдэхүүн бий болгох, бодлого зохицуулалтын орчныг шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд ашиглаж буй ногоон бонд гаргах зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын туршлага, тогтвортой санхүүгийн хандлагыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад анхаарч ажилласаар байна. Өнөөдрийн байдлаар дотоодын зах зээлд 45 сая ам.доллартай тэнцэх хэмжээний ногоон бонд бүртгэгдээд байгаа бол “Тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг”-т ББСБ-уудыг нийт зээлийнхээ 5 хувийг ногоон зээлд олгох арга хэмжээний төлөвлөгөөг тусгаснаар ногоон таксономи ангиллын хүрээнд ББСБ-уудаас олгосон нийт зээлийн 2.5 орчим хувийг

ногоон төслийн санхүүжилтэд олгожээ. Мөн байгаль орчинд ээлтэй, дулааны алдагдал багатай, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц болон автомашины ногоон даатгалын бүтээгдэхүүнтэй, “ногоон даатгал”-ын нэр, томъёоллыг даатгалын салбарын эрх зүйн орчинд тусгаад байна гэдгийг онцолсон юм.

Харин “Тогтвортой хөгжилд хөрөнгийн зах зээлийн оролцоо” салбар арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нээж үг хэлсэн бөгөөд тэрбээр тогтвортой хөгжил нь эдийн засгийн өсөлт, байгаль орчны хамгаалал, нийгмийн тэгш байдлын гурван тулгуур баганад тулгуурладаг. Хөрөнгийн зах зээл нь тогтвортой хөгжлийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл төдийгүй уялдаа холбоог хангах чухал платформ тул Санхүүгийн зохицуулах хороо энэ хүрээнд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, өнгөрсөн онд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг батламжилснаар биржийн болон биржийн бус зах зээлд ногоон бонд гаргах замаар байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх тогтолцоо бүрдсэн гэдгийг онцолсон. Мөн манай улсын байгалийн баялаг, шинэ тутам хөгжиж буй хөрөнгийн зах зээлийг тогтвортой байдлын үзэл баримтлалд тулгуурлан хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх улмаар ирээдүйд эерэг үр нөлөө үзүүлэх бодит хөшүүрэг болж чадна. Иймд Санхүүгийн зохицуулах хороо энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, ногоон, тогтвортой хөгжлийг дэмжих санхүүгийн шийдлүүдийг хөгжүүлэхэд анхаарч ажилласаар байх болно гэсэн юм.

Энэхүү салбар арга хэмжээний үеэр тогтвортой санхүү ба уур амьсгалын шилжилтийн үнэлгээний гол чиг хандлага, тогтвортой санхүүжилтэд ассет менежмент компаниудын оролцоо, олон улсын ногоон бондын санаачлага зэрэг сэдвийн хүрээнд илтгэл тавьж, дотоодын нөлөөллийн хөрөнгө оруулалтын боломж, саад бэрхшээлүүд сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв.

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭЭ



“Тэнгэр даатгал” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол боллоо. Ёслолд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монголын хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Тэнгэр даатгал” ХХК-

ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Баянмөнх, “Мандал капитал маркетс ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Өлзийдэлгэр болон холбогдох албаны бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Даатгалын салбарын хувьд 2024 он ихээхэн онцлогтой жил болж, салбарын оролцогчид 90 жилийн түүхт ойгоо амжилт арвин тэмдэглэж байна. 1934 онд анх “Улсын аюулаас хамгаалах газар” нэртэйгээр анх даатгалын байгууллагын суурь тавигдаж байсан бол өнөөдөр урт хугацааны даатгалын 2, ердийн даатгалын 16, давхар даатгалын 1, даатгалын зуучлалын компани 60, даатгалын хохирол үнэлгээний компани 29, даатгалын төлөөлөгч 2500 иргэн СЗХ-ноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж байна. Салбарт даатгагдсан хөрөнгийн үнэлгээ 2005 онд 1.5 их наяд төгрөг байсан бол өдгөө 371 их наяд төгрөг болж 247 дахин өссөн байна. Мөн энэ оны гуравдугаар улирлын байдлаар салбарын нийт актив 738 тэрбум төгрөг, даатгалын нөөц сан 349 тэрбум, хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгийн хэмжээ 101 тэрбум төгрөг байна.



## ДААТГАЛЫН САЛБАРЫН 90 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД “ДИЖИТАЛ ГАЛЕРЕЙ” ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ БОЛЛО

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгалын холбоо хамтран Монгол Улсад даатгалын тогтолцоо үүсэж бэхэжсэний 90 жилийн ойн хүрээнд “Дижитал галерей” цогц арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр даатгалын салбарын нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөг нэмэгдүүлэх талаар хэлэлцэх, гарсан үр дүнд үндэслэн зохицуулалтын болон зах зээлийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлох “Даатгал-нийгэм эдийн засгийн дархлаа” бодлогын форум, салбарын түүхэн замнал, дижитал болон инновац шийдлүүд, дотоодын нийгмийн орчны эрсдэлүүдийн танилцуулга, түүнийг хэрхэн даван туулах шийдлүүдийг танилцуулсан “Дижитал галерей” болов.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж “Даатгалын салбар улам өсөн бэхжиж, олон улсын даатгалын зах зээлийн жишиг, зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулж, даатгуулагч иргэд, байгууллагуудад олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж байгаа их амжилтаар бид ойгоо угтаж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасанчлан Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлийг олон тулгуурт

бүтцэд шилжүүлэх, даатгал болон хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх хүрээнд бодлогын шийдвэрүүдийг гарган, холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллаж ирлээ. Тухайлбал, даатгагчийн хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох зохицуулалтын орчныг өөрчлөн сайжруулснаар даатгалын компаниуд мэргэжлийн хөрөнгө оруулагчаар ажиллах боломж бүрдэж, энэ оны гуравдугаар улирлын байдлаар даатгалын компаниудын бонд, хувьцаа хэлбэрээр хөрөнгийн зах зээлд оруулсан нийт хөрөнгө оруулалт 100 тэрбум төгрөгт хүрээд байна. Мөн даатгалын компаниуд олон нийтэд нээлттэй хувьцаат компаниар бүртгүүлснээр даатгалын компаниудын хөрөнгийн зах зээл дэх оролцоо ч эрс нэмэгдсэн. Үүний үр дүнд салбарын хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн тоо 2018 оны мөн үетэй харьцуулахад 135 дахин өсөж, 24 мянгад хүрлээ. Энэ хэрээр иргэд, олон нийтийн даатгалын салбарт оролцох боломжийг нэмэгдүүлээд байна. Мөн өнгөрөгч онд УИХ-аас холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, даатгалын компаниуд даатгагчийн баталгаа гаргах хууль эрх зүйн орчныг бүрдүүлснээр даатгалын салбараар дамжуулж төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах ажиллагаандаа шаардлагатай баталгааг олон эх үүсвэрээр гаргуулах, санхүүгийн хүндрэлийг эдийн засгийн үр өгөөжтэй, түргэн шуурхай шийдвэрлүүлэх цаашилбал иргэдийн орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг үр нөлөөг үзүүлэхийн зэрэгцээ даатгалын компаниудын үйл ажиллагааны цар хүрээ өргөжих боломж бүрдсэн. Түүнчлэн салбарын эрсдэлийн хяналт, удирдлагын тогтолцоог бүрдүүлсний зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн зарчмыг хэрэгжүүлэх, дэлхий даяар тулгамдаад буй цаг уурын өөрчлөлт, байгаль орчны бохирдол зэргийг бууруулахад дэмжлэг болох зорилгоор “ногоон даатгал”-ын зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах арга хэмжээг хэрэгжүүлээ. Мөн салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах зорилгоор Даатгалын салбарын багц хуульд өөрчлөлт оруулахаар эрчимтэй ажиллаж байна” гэдгийг онцолсон юм.

## УИХ-ЫН ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО ХУРАЛДААНД ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛАВ

УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийн



талаарх мэдээллийг танилцууллаа. Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж холбогдох журам, зааврыг баталж ажиллаж байгаагийн зэрэгцээ үр дүнтэй хяналт, зохицуулалтын орчныг бүрдүүлж, ФАТФ-ын Техникийн зөвлөмж 15 (Шинэ технологи)-ийг хангаж ажиллаж байна. Виртуал хөрөнгийн салбарын зохицуулалт Монгол Улсад төдийгүй дэлхий даяар шинэлэг хэвээр байгаа ба техник технологийн хурдацтай шинэчлэлийг дагаж шинэ сорилтууд учирсаар байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн салбарын оролцогчдын үйл ажиллагааг дэмжих, тус зах зээл дэх хууль бус хөрөнгийн урсгалд хяналт тавих, илрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-нд батлагдсан бөгөөд одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн 41 байгууллага үүнээс үйлчилгээ үзүүлэгч 12 байгууллага байна. СЗХ-ноос хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор иргэд, олон нийтэд хуулийг сурталчлан таниулах чиглэлээр бүсчилсэн сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Мөн энэ үеэр тэрбээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын эрсдэлийн үнэлгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын мэдээлэл өгсөн юм.

## ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛОН БАНКНЫ САЛБАРЫН ОРОЛЦОГЧДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ УУЛЗАЛТ БОЛЛОО



Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж холбогдох журам, зааврыг баталж, үр дүнтэй хяналт, зохицуулалтын орчинг бүрдүүлж, ФАТФ-ын Техникийн зөвлөмж 15 (Шинэ технологи)-ийг хангаж ажиллаж байна. Виртуал хөрөнгийн салбарын зохицуулалт Монгол Улсад төдийгүй дэлхий даяар шинэлэг хэвээр байгаа ба техник технологийн хурдацтай шинэчлэлийг дагаж, шинэ сорилтууд учирсаар байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо виртуал хөрөнгийн салбарын оролцогчдын үйл ажиллагааг дэмжих, тус зах зээл дэх хууль бус хөрөнгийн урсгалд хяналт тавих, илрүүлэх чиглэлээр төрийн холбогдох эрх бүхий байгууллагууд, виртуал хөрөнгийн салбарын оролцогчид, арилжааны банкууд хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар уулзалт зохион

байгуулж, P2P үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр нээлттэй хэлэлцлээ.

Энэ үеэр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зах зээлд тулгарч буй эрсдэлүүдийн талаар оролцогч талууд нэгдсэн ойлголт авч, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр цаашид хийгдэх арга хэмжээг тодорхойлов.

## БНСУ-ЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ЯРИЛЦЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал БНСУ-ын Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага /FSS/-ын Хөрөнгийн зах зээл болон санхүү хариуцсан дэд дарга Хам Ёнгил /Наhm Yongil /-той уулзлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал энэ үеэр “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор хороо хэд хэдэн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний нэг нь Монголын хөрөнгийн зах зээлийг Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах, хөрөнгө оруулах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity” цуврал арга хэмжээг Хонгконг, Шанхай, Нью-Йорк, Сингапур зэрэг хотуудад зохион байгуулсан. Мөн Сөүл хотноо “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг сая амжилттай зохион байгууллаа. Хоёр орны хөрөнгийн зах зээл мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын харилцаа, холбоо тогтоох, хамтын ажиллагаа эхүүлэхэд тодорхой үр дүнтэй арга хэмжээ боллоо гэж үзэж байна” гэдгийг онцолсны зэрэгцээ сүүлийн жилүүдэд хийсэн зарим онцлох ажлуудынхаа талаар танилцууллаа. Ялангуяа хөрөнгийн зах зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бодлогоор дэмжих, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгох замаар санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийнхээ талаар мэдээлэл өгч ингэснээр Монгол Улсын макро эдийн засаг сүүлийн жилүүдэд тогтворжиж, эерэг үзүүлэлтүүдийг үзүүлж буй бөгөөд энэ оны хагас жилийн байдлаар ДНБ 5.6 хувиар өссөн харин ирэх онд 6 хувиар өснө гэсэн хүлээлттэй байгаа талаар танилцууллаа. Нөгөөтэйгүүр Хорооны зохицуулалтын цар хүрээ сүүлийн жилүүдэд хурдацтайгаар өргөжин тэлж түүнийг дагаад дэвшилтэд технологид суурилсан зохицуулалттай байгууллагуудын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэн технологид суурилсан хяналтыг нэвтрүүлэх нь чухал бөгөөд энэ чиглэлд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх мөн хоёр улсын банк, санхүүгийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам өргөжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

# ОНЦЛОХ БУЛАН

## “СИНГАПУР ФИНТЕК ФЕСТИВАЛЬ–2024”–С ОНЦЛОХ НЬ

Эхлэл нь 1–р нүүрт

Квантум тооцоолол, квантум технологи нь өгөгдлийг хурдан боловсруулах замаар санхүүгийн шийдвэр гаргах явцыг сайжруулж, квант шифрлэлтээр санхүүгийн аюулгүй байдлыг хангаж, деривативын бодит цагийн үнэлгээг хялбаршуулах, салбарын эрсдэлийн үнэлгээ, ирээдүйн таамаглалыг оновчлох зэргээр санхүүгийн салбарын томоохон асуудлуудыг урьд өмнө нь байгаагүй өндөр хурд, үр ашигтайгаар шийдвэрлэх боломжийг олгож байна. Мөн тус технологийг өндөр давтамжтай арилжаа, зээлийн үнэлгээ, оноожуулалт, зохицуулалтын шаардлагыг биелүүлэх зэрэгт ашиглах боломжтой бөгөөд санхүүгийн салбарыг бүхэлд нь өөрчлөх хүчтэй шинэ эриний технологи юм. Фестивалийн үеэр санхүүгийн системд квант технологийг үр дүнтэй нэвтрүүлэх арга замуудыг хэлэлцэн, бодлого боловсруулагчид, салбарын удирдагчид, шинийг санаачлагчдыг нэгтгэн, тус салбарын хөгжилд дэлхий нийтийн хамтын ажиллагааны ач холбогдлыг онцоллоо.

### 2. “ДЭЛХИЙН САНХҮҮ, ТЕХНОЛОГИЙН СҮЛЖЭЭ”–Г ТАНИЛЦУУЛЛАА.



“Дэлхийн санхүү, технологийн сүлжээ (GFTN)”–г технологи, инновацыг ашиглан илүү үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн эко системийг хөгжүүлэхэд дэлхий нийтийн хамтын ажиллагааг чиглүүлэх үндсэн зорилготойгоор Сингапурын Төв банк 2024 оны 10 дугаар сард үүсгэн байгуулсан бөгөөд тус

сүлжээний ерөнхийлөгчөөр Сингапурын Төв банкны гүйцэтгэх захирал асан ноён Рэви Менон томилогдсон юм. Фестивалийн үеэр ерөнхийлөгч Менон “Дэлхийн санхүү, технологийн сүлжээ”–ний дэлгэрэнгүй танилцуулга, ирэх жилүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан бөгөөд тус сүлжээ нь дараах 4 үндсэн стратегийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж. Үүнд:

- Дэлхийн санхүү, технологийн сүлжээний форумыг томоохон банк, санхүүгийн төв хотуудад зохион байгуулах;
- Санхүү, технологийн экосистемийг хөгжүүлэх, инновацыг нэвтрүүлэхэд судалгаа болон бодлогын зөвлөх үүргийг гүйцэтгэж, мэдлэгийн төв болох;
- Жижиг, дунд болон финтекийн салбарын гарааны бизнесүүдийг холбосон платформын үйлчилгээг үзүүлэх;
- Тогтвортой хөгжил, нийгмийн нөлөөлөл бүхий төслүүдийг хэрэгжүүлэх өндөр чадамжтай гарааны бизнес, технологийн компаниудыг дэмжиж, санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын санг удирдах.
- Рэви Менон, Дэлхийн санхүү, технологийн сүлжээний ерөнхийлөгч

### 3. ХИЛ ДАМНАСАН ТӨЛБӨР ТООЦООНЫ ШИЙДЭЛ ФЕСТИВАЛИЙН ГОЛЛОХ ТАЙЗЫГ ЭЗЭЛЛЭЭ.

Фестивалийн үеэр Сингапурын Төв банк болон Банкны олон улсын төлбөр тооцооны байгууллагын дэргэдэх Инновацын хаб (BIS Innovation Hub) хамтран хэрэгжүүлж буй Нексус төслийн хэрэгжилтийг хангуулах бие даасан байгууллагыг байгууллаа. Тус байгууллага нь Нексус төслийн хэрэгжилтийг хангуулах, улс орнуудын дотоодын төлбөр тооцооны системүүдийг холбоход анхааран ажиллана.

Нексус төсөл нь нэгдсэн стандарт бүхий тогтолцоог бүрдүүлж, улс орнуудын дотоодын төлбөрийн системүүдийг холбох замаар хил дамнасан төлбөр тооцоог хялбарчлах, зардал, хугацааг бууруулахад чиглэсэн төсөл юм. Тус төслийг Энэтхэг, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд зэрэг зүүн өмнөд

Азийн улсуудыг хамран хэрэгжиж буй бөгөөд 2026 он гэхэд 1.7 тэрбум хүнийг холбосон төлбөр тооцооны сүлжээг үүсгэх зорилготой.

Форумын үеэр танилцуулагдсан өөр нэгэн хил дамнасан төлбөр тооцооны шийдэл нь Ант групп болон Стандарт Чартеред банкны хамтран хэрэгжүүлж буй сингапур доллар суурьтай токений гүйлгээ хийгдэх “Ант блокчэйн” технологи юм. Тус хамтарсан төсөл нь токенжсон хөрөнгийг ашиглан хил дамнасан төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх боломжийг эрэлхийлж байна.

#### 4. ТЕНСЕНТ БОЛОН ВИЗА ХАМТРАН АЛГАНЫ ХЭЭ ТАНИХ ТӨЛБӨРИЙН ШИЙДЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА.

Тенсент групп Визатай хамтран алганы хээ танигч төлбөрийн шийдлийг хөгжүүлснээ танилцууллаа. Тус шийдэл нь Сингапурулсын виза карт эзэмшигчдийн дунданхлан нэвтэрч буй бөгөөд Сингапурын Хөгжлийн банк (DBS), Хятадын олон улсын банк (OCBC), Юнайтед оверсиз банк (UOB)–уудын харилцагчид төлбөр тооцоо хийхдээ уг шийдлийг ашиглах боломжтой. Сингапурын Алхимист кафед энэхүү төлбөрийн шийдлийг туршилтаар суурилуулсан бөгөөд шат дараатайгаар өргөжүүлэхээр төлөвлөж байна. Хэрэглэгчид эхний удаад өөрийн алганы хээг уншуулан, таниулж виза карттайгаа холбосноор, хэрэглэгчийн алганы хээнд тохирох төлбөрийн токен үүсэх аж. Улмаар хэрэглэгч дараа, дараагийн төлбөр тооцоог алганы хээгээ зайнаас уншуулах

байдлаар гүйцэтгэх боломжтой ба амар хялбар, найдвартай төлбөрийн шийдлийг хэрэглэгчдэд санал болгож байна.

#### 5. СИНГАПУР ФИНТЕК ФЕСТИВАЛИЙН ШИЛДГЭЭР “ВАЛИ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (WALEE FINANCIAL SERVICES)” ТОДРОЛОО.

“Сингапур Финтек Фестиваль” нь жил бүр шилдгүүдээ тодруулан шалгаруулдаг бөгөөд энэ жилийн тухайд нийт 200 гаруй өрсөлдөгчдөөс 5 төрлийн шилдгүүдийг олон улсын экспертүүд, салбарын мэргэжилтнүүд шалгарууллаа. Үүнд: Вали Санхүүгийн үйлчилгээ нь шинэ тутам хөгжиж буй финтек төрөлд, ПолисиСтрийт (PolicyStreet) нь санхүүгийн хүртээмжийн төрөлд, Напиер Эй Ай (NapierAI) нь зохицуулалтын манлайлал төрөлд, Ризал арилжааны банк корпорац нь тогтвортой хөгжлийн инновац төрөлд, Тенсент групп хиймэл оюун ухаан, квантум шийдлийн төрөлд тус тус тэргүүлээ.

Вали Санхүүгийн үйлчилгээ нь 2023 онд үүсгэн байгуулагдсан банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч бөгөөд Исламын банкны салбарт инновац нэвтрүүлэхээр зорьж буй юм. Харин ПолисиСтрийт нь Малайз Улсад төвтэй инсуртек компани бөгөөд даатгалын үйлчилгээг амар хялбар, хямд өртөгтэй, хүртээмжтэй болгохоор зорьж байгаа бол зохицуулалтын манлайлал төрөлд тэргүүлсэн Напиер Эй Ай нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, хиймэл оюун ухаан суурьтай зохицуулалтын технологийн шийдэл юм.



# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## УУР АМЬСГАЛЫН ШИЛЖИЛТИЙН САНХҮҮГИЙН ГАРЫН АВЛАГА

Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос 2020 онд Уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлагыг гаргасан. Энэхүү гарын авлага нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэх хүсэлтэй хөрөнгө оруулагчид бонд гаргагчид хоорондын санхүүжилтийн үр ашигтай урсгалыг хангах ба хөрөнгө босгох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, практик, тодруулгын талаар хөрөнгийн зах зээлд оролцогчдод тодорхой удирдамж, нийтлэг хүлээлтийг хангах зорилготой.

Тус гарын авлага нь дөрвөн хэсгээс бүрддэг:

- Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратеги ба засаглал;
- Бизнес загварын материаллаг байдал;
- Уур амьсгалын шилжилтийн стратеги нь "шинжлэх ухаанд суурилсан" зорилтууд болон замын зургийг багтаасан байх;
- Хэрэгжилтийн ил тод байдал.

### 1. БОНД ГАРГАГЧИЙН УУР АМЬСГАЛЫН ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИ БА ЗАСАГЛАЛ

Бонд гаргагчийн санхүүжилт босгох гол зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох стратегийг хэрэгжүүлэхэд чиглэх ёстой бөгөөд уур амьсгалын шилжилтийн стратеги нь нүүрстөрөгч багатай эдийн засагт шилжихэд эерэг хувь нэмэр оруулахын тулд бизнесийн загвараа ямар төлөвлөгөөний дагуу, арга барилаар хэрхэн өөрчилж, тохируулахыг зорьж буйг тодорхой тусгасан байх ёстой.

#### Ил тод байдал

Байгууллагын стратегитай холбоотой ил тод байдлыг Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулгын ажлын хэсгийн зөвлөмж (TCFD) зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын тогтолцоотой нийцүүлэх эсхүл компанийн уламжлалт тайлагналтай холбоотой практикаар буюу жилийн тайлан, тусгай зориулалтын тогтвортой байдлын тайлан, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгад тусгаж болно.

Тайлагналд тусгах гол үзүүлэлтүүд:

- Парисын хэлэлцээрийн зорилгод нийцүүлэх урт хугацааны зорилт (жишээлбэл, дэлхийн дулаарлыг 1.5°C хүртэл, хамгийн багадаа 2°C-ээс их хэмжээгээр хязгаарлах зорилго);
- Урт хугацааны зорилгод хүрэх замд холбогдох завсрын зорилтууд;
- Нүүрстөрөгчийг бууруулахад чиглэсэн бонд гаргагчийн хөшүүргийг тодруулж, Парисын хэлэлцээрийн зорилгод нийцүүлэх урт хугацааны зорилтод чиглэсэн стратеги төлөвлөлт;
- Шилжилтийн стратегийн тодорхой хяналт, засаглал;
- Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулах илүү өргөн хүрээтэй тогтвортой байдлын стратегийн нотолгоо.

#### Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Стратеги төлөвлөлтийн хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд бонд гаргагчийн стратегийн найдвартай байдлын талаарх хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд тусална. Энэхүү хяналт, дүгнэлт нь дараахь агуулгатай байна:

- урт болон богино хугацааны зорилтуудыг ерөнхий хувилбартай уялдуулсан байдал;
- бонд гаргагчдын стратегийн зорилтод хүрэх найдвартай байдал;
- бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийн бие даасан засаглалын түвшин ба хяналт (ТУЗ-ийн хөндлөнгийн гишүүд, бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулах эсхүл холбогдох бусад ТУЗ-ийн тусгайлсан дэд хороод).

## 2. БИЗНЕС ЗАГВАРЫН МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Уур амьсгалын шилжилтийн бонд нь бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа уур амьсгалын шилжилтийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт байх ёстой. Уур амьсгалын өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой шилжилтийн замын зураг нь нэг удаагийн биш харин бизнесийн загварын ирээдүйн амжилтад чухал хүчин зүйл болдог. Иймд тус замын зураг/стратеги нь бонд гаргагчийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх уур амьсгалын нөлөөллийн ач холбогдлыг харгалзан үзэж, сөрөг нөлөөллийг бууруулахыг эрэлхийлсэн байх ёстой.

### *Ил тод байдал*

Төлөвлөсөн шилжилтийн замын зургийн материаллаг байдлын талаарх хэлэлцүүлгийг дээр дурдсан 1 дүгээр хэсэгт дурдсан тайлагналд оруулна. Ийнхүү ил тод байдлыг тайлагнахдаа материаллаг байдлын талаар одоо мөрдөгдөж буй баримт бичиг тухайлбал, нягтлан бодох бүртгэлийн стандартын байгууллагаас гаргасан холбогдох удирдамжийг ашиглаж болно.

Уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөний стратегийн бодит байдлын талаарх хэлэлцүүлэг нь дараахыг тусгасан байна:

- бонд гаргагчаас нийтэд зарласан материаллаг байдлыг ил тод байдлаар жилийн тайланд тусгагдсан байх;
- бонд гаргагчийн нийт ялгарлын хэмжээг бууруулах зохих төслүүдийн материаллаг байдлын асуудлыг шийдвэрлэх. Материаллаг байдлыг хараахан бүрэн тодорхойлоогүй эсвэл хэмжигдээгүй байгаа тохиолдолд тайлагнах цаг хугацааг заавал ил тод болгох ёстой.

### *Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт*

Санхүүгийн тайлан, тодруулга гэх мэт баримт бичигт хөндлөнгийн хяналт хийж болно.

## 3. УУР АМЬСГАЛЫН ШИЛЖИЛТИЙН СТРАТЕГИ НЬ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙХ (ЗОРИЛТУУД, ЗАМЫН ЗУРАГ);

Бонд гаргагчийн уур амьсгалын стратеги нь шинжлэх ухаанд суурилсан зорилтууд болон шилжилтийн замын зурагтай байх ёстой. Төлөвлөсөн шилжилтийн замын зураг нь дараах шаардлагыг хангасан байна:

- тоогоор хэмжигдэхүйц байх (цаг хугацааны хувьд тогтвортой хэмжилтийн арга зүйд суурилсан);
- шинжлэх ухааны үндэслэлтэй, нийцүүлэх, харьцуулах боломжтой байх;
- олон нийтэд мэдээлэх (үндсэн санхүүжилтийн мэдүүлэгт хамгийн тохиромжтой), завсрын үе шатуудыг багтаасан байх;
- бие даасан баталгаа эсвэл баталгаажуулалт хийгдсэн байх.

Мөн энэхүү хэсэгт Парисын хэлэлцээрт нийцсэн байдал, зах зээл болон оролцогч талуудын хүлээлт, компанийн гарааны цэг, ололт амжилт, эдийн засгийн хязгаарлалт/зардал–үр ашгийн шинжилгээ, баталгаат техник, технологи байгаа эсэх талаар тусгана.

### *Ил тод байдал*

Уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөнд дараах ил тод байдлын мэдээлэл, үзүүлэлтүүдийг тусгана:

- Уур амьсгалын шилжилтийн ерөнхий стратеги болон уур амьсгалын шинжлэх ухаанд нийцсэн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөгөө, энэхүү төлөвлөгөө нь байгууллагын хөрөнгө оруулалтын зардлын шийдвэр гаргахад хэрхэн тусгагдсан тухай хэлэлцүүлэг;
- Уур амьсгалын шилжилтийн стратегид үл нийцэх үйл ажиллагаа/бүтээгдэхүүнийг үе шаттайгаар зогсоох төлөвлөгөө;
- Ногоон бондын зарчмуудад хамаарах боломжтой ногоон төслийн ангилалд дурдсан төслүүдийг нийт хөрөнгө оруулалтын зардлын хувиар илэрхийлж энэ харьцаа цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөхийг тооцоолох;
- Гол тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнээс гарч болзошгүй хүлэмжийн хийн ялгаралтын чанарын болон/эсвэл тоон үнэлгээ;
- Нүүрстөрөгчийг бууруулах дотоод зардлын талаарх таамаглал;
- Ажиллах хүчин, олон нийт, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, тэдгээр сөрөг нөлөөллийг бууруулахад ашигласан холбогдох стратегийн талаарх тодруулга.

*Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт*

Хяналт баталгаажуулалтын хувьд "нүүрстөрөгчийг бууруулах замын зураг"-ийг хянаж энэ нь 1 дүгээр хэсэгтэйгээ хэр зэрэг нийцэж байгаа талаар санал дүгнэлт гаргах зорилготой хөндлөнгийн хяналтын үйлчилгээг зөвлөдөг. Хэрэв тодорхой баталгаа, баталгаажуулалт хийгдээгүй бол бонд гаргагч нь хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөнүүд нь хүлэмжийн хийг бууруулах стратегийг хэрхэн дэмжих төлөвтэй байгаа талаар хэтийн төлөвтэй дүн шинжилгээ хийх ёстой. Ерөнхийдөө хэд хэдэн хэмжүүрээр хянаж болно:

- бонд гаргагчийн ногоон/тогтвортой байдлын зардлын нийт зардалд эзлэх хувь;
- ногоон/тогтвортой байдлын зардлын хэмжээ;
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үр дүн эсвэл ногоон/тогтвортой байдлын бондын зарцуулалтаар хүрсэн эсвэл хүрэхээр хүлээгдэж буй үр өгөөж, мөн ногоон бус үйл ажиллагаанд зарцуулсан зардлын бууруулсан хэмжээ.

**4. ХЭРЭГЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө босгох зах зээлийн харилцаанд хөрөнгө оруулалт, судалгаа хөгжүүлэлтийн зардал, үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл болон засаглал, үйл явцын өөрчлөлт зэргийг үндсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн боломжит хэмжээнд ил тод байлгах ёстой.

*Ил тод байдал*

Хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө болон бусад холбогдох санхүүгийн мэдээлэл болон шилжилтийн стратегитай холбоотой мэдээллийг компанийн жилийн тайлан, вэбсайт эсвэл тогтвортой байдлын тайлангаар дамжуулан гаргаж болно. Урьдчилан тооцоолсон үнийн дүнгийн дагуу тодорхой элементүүд болон зарласан стратегитай тэдгээрийн холболтыг нарийвчлан харуулсан энгийн хүснэгтийн хэлбэрээр хүлээгдэж буй хөрөнгийн болон төлбөрийн баримтуудыг тодруулах боломжтой. Тайлагналд тусгах гол үзүүлэлтүүд:

- Дээрх 1 дүгээр хэсгийн ил тод байдалд тодорхойлсон үзүүлэлтүүдийн дагуу хөрөнгө/орлого/зарлагын хувь хэмжээний талаарх тайлан;
- Ерөнхий стратеги болон уур амьсгалд нийцсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт.

*Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт*

Дээр дурдсан хэтийн төлөвтэй зардлын төрлийг үнэн зөв урьдчилан таамаглахад хүндрэлтэй байдаг тул хөрөнгө оруулалтын болон ашиглалтын төлөвлөгөөний баталгаажуулалт (жишээлбэл, зарлага анх төлөвлөсний дагуу хийгдсэн эсэхийг үнэлэх) тохиромжгүй байх магадлалтай. Иймд компани өөрөө үр дүн нь анхны төлөвлөгөөтэй хэр зэрэг нийцэж байгаа, тухайлбал, зарцуулалт нь хүлээгдэж буй байдлаар хийгдсэн эсэх, мөн хийгээгүй тохиолдолд шалтгааны талаар тайлбар өгөх талаар дүн шинжилгээ хийж танилцуулна.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аж ахуйн нэгж, байгууллагын хувьд сорилт, ололт амжилт бүхий дараагийн санхүүгийн жил ойртож буй өнөө үед төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), гүйцэтгэх удирдлага, компанийн засаглалын мэргэжилтнүүдийн анхаарлыг татдаг чухал асуудлуудын нэг нь ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөөг батлах юм.

Энэхүү стратегийн зураглал нь хэвшсэн албан ёсны үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээтэй бөгөөд тухайн жилд хүчин зүтгэлтэй, амжилттай ажиллах суурийг бүрдүүлэгч үндсэн хөдөлгөх хүч болдог. Түүнчлэн, ажлын төлөвлөгөө нь энгийн өдөр тутмын ажлын жагсаалт бус харин үйл ажиллагааны замын зураглал юм.

ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааг алсын хараатай холбох гол зангилаа болж, гаргасан шийдвэр бүр нь байгууллагыг стратегийн зорилгодоо хүрэхэд нь түлхэц өгч байдаг.

Сайн боловсруулсан жилийн ажлын төлөвлөгөө нь дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг баталгаажуулан, учирч болзошгүй эрсдэл бүрийг тооцож, түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх цогц стратегийг бий болгох ёстой.

ТУЗ-ийн ажлын төлөвлөгөө нь тасралтгүй суралцах, ТУЗ-ийн үнэлгээнд анхаарал хандуулах зэргийг хамарсан ТУЗ-ийн эрхлэх асуудалд зохион байгуулалттайгаар, дэс дараатай хандах хүрээг тогтоож өгдөг. Ингэснээр амжилттай ажиллах үндсийг бүрдүүлж, өөрийгөө үнэлэх явцыг идэвхжүүлдэг төдийгүй оролцогч талууд хооронд мэдээллийн урсгалыг сайжруулж, үр дүнтэй харилцааны сувгуудыг тодорхойлно.

Ажлын төлөвлөгөөг тасралтгүй хөгжүүлэн идэвхжүүлж байх ёстой байнгын хэрэглээний баримт бичиг гэдгийг анхаарч, уян хатан байдлыг хангаж, аливаа шинээр гарч ирж буй хандлага, сорилт, боломжид тохирсон хариу арга хэмжээ авахад бэлэн байх шаардлагатай.

ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах, гишүүдийн анхаарал хандуулах, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар зарим чухал асуудлыг дурдвал:

### ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хуралдах огноо, хэлэлцэх асуудал

Цагийг үр дүнтэй ашиглахын тулд хурлын огноо болон хэлэлцэх асуудлыг тодорхойлох, түүнчлэн, хурлын өмнө бэлтгэлийг хангахын тулд шаардлагатай бичиг баримт танилцуулах хугацааг тодорхойлж тусгах

### Хууль, тогтоомжид заасан хугацааг баримтлах

Компанийн санхүүгийн тайланг батлах, зохицуулалтын шаардлага болон бусад хуулиар хүлээсэн үүргүүдийн эцсийн хугацааг онцлон тэмдэглэх

### Сургалтын төлөвлөгөө

Салбарын хөгжлийн чиг хандлага, компанийн засаглалын практикт нийцүүлэн ТУЗ-ийн гишүүдийг сургалтад хамруулах төлөвлөгөөг боловсруулах

### Зохион байгуулалтын арга хэмжээ

Байгууллагын гадагшаа хандсан үйл ажиллагаа (нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх санаачлага, бүтээгдэхүүн, үйлчилгээ, оролцогч талууд, хөрөнгө оруулагчдын талаарх танилцуулга, шагнал гардуулах ёслол гэх мэт)–г тодорхойлох


Эцэст нь ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө нь дээр дурдсанчлан албан ёсны үйл ажиллагааны хүрээнээс илүү өргөн, ил тод, хариуцлагатай байдал, тасралтгүй сайжруулалтын төлөө амлалт байх бөгөөд тэрээр зохистой засаглалын мөн чанарын биелэл юм.

## ФИНТЕК БА РЕГТЕК


### 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ДЭЛХИЙН ФИНТЕКИЙН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2024 оны 8 дугаар сард нийтлэгдсэн бөгөөд 2024 оны эхний хагас жилд дэлхийн финтек хөрөнгө оруулалт 51.9 тэрбум ам.долларт хүрсэн нь 2023 оны хоёрдугаар хагас жилд байсан 62.3 тэрбум ам.доллараас буурсан үзүүлэлт юм. Үүний дотор нийт хэлцлийн тоо 2,287-оос 2,255 болж буурчээ. Бүс нутгийн хэмжээнд Америк тивийн хөрөнгө оруулалт 38.5 тэрбум ам.доллараас 36 тэрбум ам.доллар болж буурсан бол Европ, Ойрх Дорнод, Африк (EMEA) бүс нутаг 19.1 тэрбум ам.доллараас 11.4 тэрбум ам.доллар болж огцом уналт үзүүлсэн байна. Ази, Номхон далайн бүс (ASPAC)-д хөрөнгө оруулалт 4.6 тэрбум ам.доллараас 3.7 тэрбум ам.доллар болж буурчээ.

Зураг. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо




Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь Venture capital хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь M&amp;A /merge and acquisition/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь PE /private equity/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



2024 оны эхний хагас жилд финтек хөрөнгө оруулагчид болгоомжтой хандсаар, зөвхөн онцгой тохиолдлуудад том хэлцлүүд хийх хандлагатай байв. Макро эдийн засгийн нөхцөл байдал 2024 оны хоёрдугаар хагас жилд ч хүнд хэвээр байх төлөвтэй, мөн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль дөхөж буйтай холбоотойгоор финтек хөрөнгө оруулалт намжмал байдалтай хэвээр байх төлөвтэй байна.

2024 оны 2 дугаар хагас жилийн финтекийн салбарын анхаарах чиг хандлага:

**Хиймэл оюун ухаан (AI) финтек хөрөнгө оруулагчдын сонирхлыг улам татах болно:** Хиймэл оюун ухаан (AI) нь хөрөнгө оруулагчдын сонирхол болон хөрөнгө оруулалтын хэмжээгээр бусад бүх салбараас давамгайлах төлөвтэй байна.

**Төлбөрийн системийн салбар хөрөнгө оруулалтыг давамгайлсаар байх болно:** Төлбөрийн системийн шинэчлэл, ялангуяа B2B төлбөр, суурилагдсан төлбөр болон бодит хугацааны төлбөрт чиглэсэн томоохон хэлцлүүд хийгдсээр байх төлөвтэй байна.

**Regtech илүү их анхаарал, хөрөнгө оруулалт татах болно:** Хууль, зохицуулалтын хүрээ байнга шинэчлэгдэж, тайлангийн шаардлага улам төвөгтэй болж буй тул Regtech салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай байна.

**DORA хөрөнгө оруулагчдыг кибер аюулгүй байдалд төвлөрүүлнэ:** Кибер аюулгүй байдал финтек хөрөнгө оруулагчдын гол анхаарлын нэг хэвээр байх бөгөөд ялангуяа ЕХ-ны Дижитал үйл ажиллагаа ба тогтвортой байдлын тухай хууль (DORA) 2025 оны эхээр хүчин төгөлдөр болох тул AI-тай холбоотой кибер аюулгүй байдлын шийдлүүд хамгийн их сонирхол татах болно.

**Уламжлалт санхүү (trad-fi) ба төвлөрсөн бус санхүү (de-fi)-ийн уялдаа нэмэгдэнэ:** Төр, засаг захиргааны байгууллагууд уламжлалт санхүүг төвлөрсөн бус санхүүтэй уялдуулсан үйл ажиллагааг судалж, баталсаар байх бөгөөд үүнд бодит хөрөнгийг токенжуулах, крипто хөрөнгө оруулалтыг дэмжих уламжлалт санхүүгийн дэд бүтцийг ашиглах зэрэг чиглэл багтана.

# СУДЛААЧИЙН ИНДЭР

## УУР АМЬСГАЛЫН БОНДЫН СТАНДАРТ, ШААРДЛАГА: ОЛОН УЛСАД

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

### Гүйцэтгэсэн:

Д.Даваамаа, СЗХ, ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн,  
davaamaa@frc.mn

### УДИРТГАЛ

Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь урт хугацааны турш дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүдсэн агаар мандал, далай, хуурай газрын дулаарлыг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь амьдрал, биологийн олон янз байдлыг дэмждэг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахын зэрэгцээ хүн, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж эхэлсэн (UNDP 2023). Иймд 2020 оноос хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж агаар дахь нүүрсхүчлийн хийг бууруулах, дэлхийн дулаарлыг зогсоох зорилгоор Парисын хэлэлцээрийг 2015 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенцын 21 дэх чуулга уулзалт (COP21)-ын үеэр соёрхон баталсан. Тус конвенцод нэгдэн орсон улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 2 хэмээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлаж, агаарын температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн түвшингээс 1.5 хэмээр хязгаарлах хүчин чармайлт гаргах үүрэг хүлээсэн (Sovereign Sustainable Finance Committee 2023). Харин Монгол Улс нь 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцын Парисын хэлэлцээрийг соёрхон баталж нэгдсэн дүнгээр үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.89 сая тонн-той дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах амлалт өгсөн (Монгол улсын засгийн газрын 407 дугаар тогтоол, 2019). Ийнхүү тус баримт бичгийн хэрэгжилтийг хангахын тулд Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлж байна. Мөн 2022 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын бүтээн байгуулалтыг

эрчимжүүлсэн, нэгдмэл бүтээн байгуулалт, олон талт санхүүгийн бүтээмжийг 2030 он хүртэл нэмэгдүүлэх, бүс нутагтаа санхүүгийн тогтвортой мэдлэг, манлайлах төв болох, үйлдвэрлэлийн стратегийн чиглэл, арга замыг тодорхойлсон “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталсан. Тус баримт бичгийн Ногоон, тогтвортой хөгжлийн, уур амьсгалын хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Ногоон, уур амьсгалын санхүүгийн бүтээгдэхүүнүүд, санхүүгийн хэрэгслүүдийг стандартчилах боломжийг судлах, нэвтрүүлэх:

- эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, бизнесийн зээл;
- ногоон/ ТоХ-д чиглэсэн хэрэглээний болон бичил зээл;
- ногоон/ ТоХ-д чиглэсэн ЖДҮ/ бизнесийн зээл;
- ногоон/ ТоХ-д чиглэсэн цахим санхүүгийн бүтээгдэхүүн;
- ногоон/ ТоХ-д чиглэсэн ипотекийн зээл;
- жендерийн мэдрэмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн;
- бусад уур амьсгалын өрийн хэрэгслүүд” гэж заасны дагуу энэхүү судалгаагаар уур амьсгалын өрийн хэрэгслийн олон улсын стандарт болон Кени, Мавраки улсын ногоон/уур амьсгалын бондын сайн туршлагыг судаллаа.

Уг судалгааны ажил нийт 4 бүлэгтэй. Судалгааны хоёр, гурав дугаар бүлэгт харгалзан Олон улсын ногоон/ уур амьсгалын бондын стандарт, баримт бичгүүд болон олон улсын сайн туршлагын талаар тусгасан. Харин эцсийн тавдугаар бүлэгт дүгнэлт, саналыг оруулав.

## НОГООН/ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ЧИГЛЭСЭН БОНДЫН ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ

### Ногоон бондын зарчмууд

Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)–оос 2021 онд Ногоон бонд гаргах арга замыг тодорхой болгох, ногоон бондын зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шударга байдлыг дэмжих зорилгоор Ногоон бондын зарчмууд (GBP) удирдамжийг гаргасан. Энэхүү ногоон бондын удирдамж нь орлогын ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент болон тайлагнах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг ба нэмэлтээр тус удирдамжид ногоон бондын танилцуулга, хөндлөнгийн хяналтын талаарх зөвлөмж багтсан.

Хүснэгт. Ногоон бондын зарчмуудын үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэг

Орлогын ашиглалт	Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц	Орлогын менежмент	Тайлагнах
<p>Үнэт цаасны хууль эрх зүйн баримт бичигт бондын орлогыг Ногоон төслүүдэд<sup>2</sup> зарцуулах талаарх зохицуулалтыг тусгах;</p> <p>Ногоон төсөл нь байгаль орчны хувьд тодорхой үр өгөөжийг бий болгох ёстой ба бонд гаргагч нь үүнийг үнэлэн тоон үзүүлэлтээр тодорхойлох;</p> <p>Бонд гаргагчид орлогыг бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийн санхүүжилтийн хувийн жингийн тооцоог гаргаж шаардлагатай бол ямар хөрөнгө оруулалт эсвэл төслийн багцад хөрөнгө оруулж байгааг тодруулж мэдээлэх.</p>	<p><i>Ногоон бонд гаргагч нь хөрөнгө оруулагчдад дараахыг тодорхой мэдэгдэх ёстой:</i></p> <p>Ногоон төслүүдийн байгаль орчин тогтвортой байдлын зорилтууд;</p> <p>Тус төсөл нь Ногоон төслүүдийн ангилалд нийцэж байгааг тодорхойлж үйл явц;</p> <p>Бонд гаргагч холбогдох төсөлтэй холбоотой нийгэм, байгаль орчны эрсдэлийг тодорхойлон, түүнийг удирдах үйл явцын талаарх мэдээлэл.</p> <p><i>Бонд гаргагчдыг дараахыг хийхийг зөвлөж байна.</i></p> <p>Байгаль орчны тогтвортой байдалтай холбоотой Бонд гаргагчийн ерөнхий зорилго, стратеги, бодлого болон/ эсвэл үйл явцын хүрээнд дээр дурдсан мэдээллийг байршуулах;</p> <p>Төслийг ногоон ангилал зүйд нийцүүлэх, холбогдох шалгууруудын талаар мэдээллээр хангах;</p> <p>Ногоон стандарт, гэрчилгээг ил тод байршуулах;</p> <p>Холбогдох төсөл(үүд)–ийн нийгэм болон/эсвэл байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдэлийг бууруулах хүчин зүйлсийг тодорхойлох.</p>	<p>Ногоон бонд гаргаж татан төвлөрүүлсэн орлого, түүний хуваарилалтыг хянах шаардлагатай. Бонд гаргагч нь тухайн орлогыг хянах системийг бий болгож, орлогыг тусгай дэд дансанд байрлуулах замаар зохицуулна. Энэ нь мөнгийг зөвхөн байгаль орчинд ээлтэй төслүүдэд, буюу Ногоон төслүүдэд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>Мөн энэхүү үйл явцыг ногоон төслүүдэд чиглэсэн зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбон дотооддоо баталгаажуулах ёстой.</p> <p>Ногоон бондын орлогын үлдэгдэл байгаа тохиолдолд тухайн хугацаанд хийгдсэн ногоон төслүүдийн хуваарилалтад нийцүүлэн хянаж, орлогын үлдэгдлийг дахин тохируулж байх;</p> <p>Бонд гаргагч нь хуваарилагдаагүй бондын орлогын үлдэгдлийг түр хугацаагаар хаана, хэрхэн байршуулах тохиолдолд хөрөнгө оруулагчдад заавал мэдэгдэх ёстой;</p> <p>Бонд гаргагчийн орлогын хуваарилалтыг хөндлөнгийн аудитор эсвэл бусад гуравдагч этгээдээр баталгаажуулах.</p>	<p>Бонд гаргагчид орлого ашиглалтын талаарх шинэчилсэн мэдээллийг орлогыг бүрэн хуваарилах хүртэл жил бүр, аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухай бүрд гаргаж танилцуулах;</p> <p>Жилийн тайланд ногоон бондын хөрөнгөөс хуваарилагдсан төслүүдийн жагсаалт, мөн төслүүдийн товч тодорхойлолт, хуваарилсан дүн, тэдгээрийн хүлээгдэж буй үр нөлөөг тусгасан байх;</p> <p>Нууцлалын гэрээ, өрсөлдөөний асуудал эсвэл олон тооны суурь төслүүдийн нарийвчилсан мэдээллийг задруулах боломжгүй тохиолдолд ерөнхий нэр томъёогоор эсвэл багцын үндсэн дүнгийн хувиар танилцуулах;</p> <p>Гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтүүдийг ашиглах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийн тоон хэмжүүр, түүнийг тодорхойлоход ашигласан үндсэн аргачлалын талаар тодруулга өгөх.</p>

Эх сурвалж: ICMA (2021), *Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds*

<sup>2</sup> Ногоон төслүүдийн ангилалд дараах багтана:

Сэргээгдэх эрчим хүч; Эрчим хүчний хэмнэлт; Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах; Амьд байгалийн нөөц ба газар ашиглалтын байгаль орчинд ээлтэй тогтвортой менежмент; Хуурай газрын болон усны биологийн олон янз байдлыг хамгаалах; Цэвэр тээвэр; Ус, бохир усны тогтвортой менежмент; Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох; Тойрог эдийн засагт тохирсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи, үйл явц; дахин ашиглах боломжтой, шинэчлэгдсэн материал, эд анги, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх; Байгаль орчны гүйцэтгэлийн хувьд бүс нутаг, үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, гэрчилгээг хангасан ногоон байгууламж. (Тодорхой дарааллаар жагсаагдаагүй бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно)

Түүнчлэн, Ногоон бондын зарчмууд удирдамж нь бонд гаргагчид ногоон бондын хөтөлбөрөө Ногоон бондын зарчмуудын 4 бүрэлдэхүүн хэсэгтэй хэрхэн уялдаж байгаа талаар ногоон бондын танилцуулга холбогдох баримт бичигт тайлбарлах, тус баримт бичгүүдийг хөрөнгө оруулагчдад ойлгоход хялбар хэлбэрээр ашиглах боломжтой байдлаар танилцуулах, төслийг сонгон шалгаруулахдаа ногоон ангилал зүй, ногоон стандарт эсвэл гэрчилгээг ил тод болгохыг зөвлөдөг. Харин хөндлөнгийн хяналтын хувьд бонд гаргасны дараа хөндлөнгийн аудитор эсхүл бусад гуравдагч этгээдээр ногоон бондын орлогоос төслүүдэд зарцуулж буй хөрөнгийн дотоод хяналт, хуваарилалтыг шалгуулж баталгаажуулахыг зөвлөдөг. Мөн улс орнууд ICMA-гийн хөндлөнгийн хяналтын загварыг ашиглах боломжтой.

### Уур амьсгалын бондын стандарт

Уур амьсгалын бондын стандарт нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох зорилгоор санхүүжилт босгож буй байгууллагуудад зориулсан сайн дурын схем юм. Энэхүү стандартыг анх 2012 онд Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг дайчлах зорилготой ашгийн бус байгууллага болох Уур амьсгалын бондын санаачилга (Climate Bonds Initiative)–аас ногоон бонд болон бусад өрийн хэрэгсэлд итгэх хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан бөгөөд тус баримт бичгийн шинэчлэгдсэн хувилбар нь 2024 оны 2 дугаар сард нийтлэгдсэн. Уур амьсгалын бондын стандарт ба баталгаажуулалт нь ICMA-ийн Ногоон бондын зарчмууд дээр суурилдаг ба бонд гаргагч нь орлого ашиглалтын гэрчилгээгээр орлогыг ногоон төсөлд зарцуулна гэдгээ баталгаажуулдаг. Орлого ашиглалтын гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг бонд гаргахаас өмнөх болон гаргасны дараах гэж ангилдаг.

### Бонд гаргахаас өмнөх гэрчилгээжүүлэлтийн шаардлага

Бонд гаргахын өмнөх гэрчилгээ авах хүсэлтэй бонд гаргагч нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна:

Бонд гаргагч нь дотоод үйл явц, хяналтын тогтолцоо бий болгосон байх;

Дотоод үйл явц, хяналтын баримт бичиг нь уур амьсгалын бондын стандартад нийцүүлэхэд боломжтой байх;

Бонд гаргагч нь ногоон өрийн хэрэгслийг гаргахтай холбоотой ногоон бондын зарчмууд (орлого ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент, тайлагнах үе шат)–ыг хэрхэн хангаж байгааг тайлбарласан баримт бичгийг боловсруулсан байх зэрэг багтана.

Тус баримт бичгийн орлого ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент, тайлагнах гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах мэдээллийг тусгасан байна:

#### 1. Орлогын ашиглалт:

Бонд гаргагч нь өрийн хэрэгсэлтэй холбогдох боломжтой төсөл, хөрөнгийг баримтжуулах, түүний жагсаалтыг гаргах ёстой.

Бонд гаргагчийн өрийн хэрэгслийн хүлээгдэж буй цэвэр орлого нь санал болгож буй төсөл, хөрөнгөд оруулсан нийт хөрөнгө оруулалтын эрсдэл, нийт дүнгээс ихгүй байна.

Бонд гаргагч нь ногоон бондоор хэрэгжүүлэхээр нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийг бусад бондоор санхүүжүүлэхгүй байх.

#### 2. Төсөл, хөрөнгийг үнэлэх, сонгох үйл явц:

Бонд гаргагч нь төсөл, хөрөнгийн сонгох шалгаруулах шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулж, хадгалах ёстой.

Шийдвэр гаргах үйл явцад дараах зүйлийг авч үзнэ:

бондын уур амьсгалтай холбоотой зорилго;

бондын уур амьсгалтай холбоотой зорилтууд (бонд гаргагчийн байгаль орчны тогтвортой байдалтай холбоотой ерөнхий зорилго, стратеги, бодлого);

бонд гаргах үндэслэл;

төсөл, хөрөнгө нь уур амьсгалын бондын стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон процесс;

төсөл, хөрөнгөтэй холбоотой байгаль орчны болон засаглалын материаллаг эрсдэлийг тодорхойлох, удирдах үйл явц;

төсөл, хөрөнгийг сонгохдоо дурдсан аливаа ногоон стандарт эсвэл гэрчилгээ.

### 3. Орлогын менежмент:

Бонд гаргагч нь орлогыг удирдахад ашиглах систем, бодлого, үйл явцаа баримтжуулж, Баталгаажуулагчид хүргүүлэх ба үүнд дараах зохицуулалтыг багтаасан байх ёстой:

- орлогыг хянах: өрийн хэрэгслийн цэвэр орлогыг дэд дансанд байршуулах, зохих журмын дагуу хэрхэн хянаж, баримтжуулах талаар;
- хуваарилагдаагүй цэвэр орлогын үлдэгдлийг хэрхэн удирдах талаар;
- төсөл, хөрөнгийн санхүүжилтийг удирдах, бүртгэх үйл явц.

### 4. Тайлагнал:

Бонд гаргагч нь ногоон санхүүжилтийн танилцуулгыг боловсруулан бонд гаргахаас өмнө эсвэл гаргах үедээ олон нийтэд мэдээлэх ёстой. Ногоон бондын бодлогын танилцуулгыг баталгаажуулалтын баримт бичгийн нэг болгон Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанд хүргүүлнэ.

Ногоон бондын танилцуулгад дараахыг тусгасан байх ёстой:

- уур амьсгалын бондын стандарт, Ногоон бондын зарчим эсвэл НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг холбогдох стандартад нийцсэн тухай;
- орлогын хүлээгдэж буй ашиглалтын талаар;
- төсөл сонгох шийдвэр гаргах үйл явц;
- бонд гаргагчийн орлогыг удирдах үйл явц;
- бонд гаргагчийн тайлагнах, хөндлөнгийн хяналт болон баталгаажуулах үйл явц;
- нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэл нь холбогдох салбарын ангилал зүй болон бонд гаргагчийн тодорхойлсон бусад нэмэлт шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах аргачлал, таамаглалын талаарх мэдээлэл;
- хуваарилагдаагүй орлогыг удирдах үйл явц хяналтын талаар;
- уур амьсгалын бондын стандартад нийцэж байгаа эсэхийг дахин баталгаажуулах үед шинэчилсэн мэдээлэл, тайлангуудаар хэрхэн хангах талаарх төлөвлөгөө;
- санхүүжүүлэх төсөл, хөрөнгийн жагсаалт, нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн хамаарах хөрөнгө оруулалтын чиглэлийн талаарх мэдээлэл.

Тухайлбал, төсөл хөрөнгийн мэдээллийг олон нийтэд ил тод болгоход хязгаарлалт байгаа тохиолдолд яагаад хязгаарлагдмал байгаа талаарх тайлбарыг оруулах;

- бондын орлогын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэхэд ашиглаж байгаа бол дахин санхүүжүүлэхэд төсөл, хөрөнгийн талаарх мэдээлэл.

Олон улсын байгууллагуудын зүгээс Бонд гаргагчдыг санхүүжүүлэх төсөл, хөрөнгийн талаар аль болох их мэдээлэл өгөхийг уриалдаг хэдий ч ихэнх тохиолдолд бонд гаргахаас өмнө төсөл, хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг задруулах боломжгүй байдаг. Энэхүү хязгаарлалт нь төсөл хэрэгжүүлэгчтэй хийсэн нууцын гэрээ, өрсөлдөөнт хүчин зүйлс зэрэг байдлаас шалтгаалан нарийн мэдээллийг задруулахыг хязгаарласан хуулиар зохицуулсан байдаг.

Бонд гаргагч нь олон нийтэд нээлттэй байршуулах мэдээлэлд дараахыг тусгасан байх ёстой.

- нэр дэвшсэн төсөл, хөрөнгийн хөрөнгө оруулалтын чиглэл;
- хуваарилагдаагүй цэвэр орлогыг удирдахад зориулагдсан богино хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгслийн төрлүүд;
- баталгаажуулалтын талаар;
- бондын орлогын үлдэгдэлтэй үед уур амьсгалын бондын стандартад нийцэж байгаа эсэхийг дахин баталгаажуулахад шаардлагатай мэдээлэл, тайлангуудыг гаргаж өгөх үйл явц;
- гэрчилгээжүүлэх гэрээнд заасан уур амьсгалын бондын санаачилгаас татгалзах тухай мэдэгдэл.

### ***Бонд гаргасны дараах гэрчилгээжүүлэлтийн шаардлага***

Энэ хэсэгт бонд гаргасны дараа гэрчилгээ авахыг хүссэн бонд гаргагч, түүний баримт бичигт тавигдах шаардлагуудыг тодорхойлсон.

#### 1. Орлогын ашиглалт:

- Бондын орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилсан байх.
- бүх төсөл, хөрөнгө нь бонд гаргагчийн ногоон бондын бодлогын баримт бичигт заасан зорилтуудыг хангасан байх.
- Бонд гаргагчид бондын орлогын 95-аас доошгүй хувийг салбарын ангилал зүйн шаардлагыг хангасан төсөл, хөрөнгөд хуваарилсан байх ба салбарын шалгуурыг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг

санхүүжүүлсэн орлогын бонд гаргагч нь ногоон бондын бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тодруулга өгөх шаардлагатай.

- Салбарын шалгуурыг бүрэн хангаагүй аливаа нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгө нь дараах бүх нөхцөлийг хангасан тохиолдолд хамрагдах боломжтой гэж үзэж болно:
  - » Уур амьсгалын бондын санаачилгын салбарын ангилал зүйд хараахан ороогүй/ боловсруулаагүй салбаруудтай холбоотой байх;
  - » Ногоон бондын зарчмууд эсвэл Нийгмийн бондын зарчмуудад тусгасан Ногоон төслийн аль нэг ангилалд багтсан;
  - » Баталгаажуулах тайлангийн дүгнэлт нь Ногоон/Нийгмийн бондын зарчимтай нийцэж байгаа нь батлагдсан;
  - » Тус төсөл нь дараах үйл ажиллагааны аль нэгэнд хамаарахгүй байх:
    - ◆ Уламжлалт болон уламжлалт бус чулуужсан түлшний нөөцийг хайх, олборлох, тээвэрлэх;
    - ◆ Байгалийн хийн үйлдвэрлэл;
    - ◆ Түүхий нефтийг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
    - ◆ Эрчим хүч үйлдвэрлэх болон дулааны зориулалтаар чулуужсан түлш нийлүүлэх ба/эсвэл ашиглах.
- Бонд гаргагч нь өрийн хэрэгсэл гаргаснаас хойш 24 сарын дотор орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилах ёстой. 24 сарын эцсийн хугацааг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын алба 5 хүртэл жилээр (мөн санхүүжүүлэх төслүүдийн шинж чанараар зохих ёсоор үндэслэлтэй бол онцгой тохиолдолд 10 жил хүртэл) сунгаж болно. Хугацааг сунгах үндэслэлийг Бонд гаргагч нотолж, баталгаажуулалт хийгдсэн тохиолдолд сунгалтыг хийнэ. Баталгаажуулалтад заасан хуваарилалтын хугацаа дуусахад Бонд гаргагч нь ахин баталгаажуулалт хийлгэж бонд гаргасны дараах баталгаажуулалтын тайланг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албаны даргад хүргүүлнэ. Баталгаажуулагч орлогын 100%

хуваарилагдсан болохыг батлах хүртэл Бонд гаргагч жил бүр бонд гаргасны дараах баталгаажуулалтын тайланг хүргүүлнэ.

- Бонд гаргагч нь албан ёсны дотоод хяналтын тогтолцооны дагуу бондын цэвэр орлогыг хянах ёстой.
- Нэмэлтээр санхүүжүүлэх төслийн хувьд тус төсөл нь уур амьсгалын стандартын шаардлагад нийцсэн тохиолдолд төсөл, хөрөнгийн багцад нэмж, оруулж болно.

#### 2. Төсөл, хөрөнгийг үнэлэх, сонгох үйл явц:

- Бонд гаргагч нь нэр дэвшүүлсэн төсөл нь цаашид хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлон шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулж, хөтөлсөн байх ёстой.

#### 3. Орлогын менежмент:

- Бондын орлогыг дэд дансны байршуулж, зохих журмын дагуу тодорхойлж, баримтжуулсан байх ёстой.
- Бонд гаргагч нь төсөл, хөрөнгөд орлого хуваарилах үйл явцыг хөтөлж, баримтжуулсан байх ёстой.
- Бондын орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилах хүртэл дараах байдлаар зохицуулна:
  - » бэлэн мөнгө, мөнгөний зах зээлийн хэрэгсэл эсвэл бусад хөрвөх чадвартай, богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулах;
  - » аливаа түр зуурын төсөлд богино хугацаат хөрөнгө оруулалтын хэлбэрээр хөрөнгө оруулах.

#### 4. Бонд гаргасны дараах тайлагнал:

- Баталгаажсан бонд гаргасны дараа гэрчилгээг хүчинтэй хэвээр нь хадгалахын тулд бонд гаргасан өдрөөс хойш 12–24 сарын дотор шинэчлэлийн тайланг ирүүлэх ёстой.
- Бонд гаргагч нь материаллаг өөрчлөлт гарсан тохиолдолд шинэчилсэн тайланг тухай бүр гаргах ёстой. Материаллаг өөрчлөлт гэдэгт эрт эргэн төлөлт, хяналт, худалдан авалт, нэр солигдох, хөрөнгө, шалгуур үзүүлэлт хангасан байдал, гүйлгээний баримт бичигт хийсэн нэмэлт

- өөрчлөлтүүд, ялангуяа татан буулгах үйл явц, түүний хэрэгжилтийн талаар зэрэг орно.
- Бонд гаргагч шинэчилсэн тайлангаа бондын зах зээлийн тайлангийн сувгуудаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
  - Шинэчлэгдсэн тайлан нь хуваарилалтын тайлан, шалгуур үзүүлэлт, нөлөөллийн тайлан гэсэн гурван төрлийн тайланг агуулна:
    - » Хуваарилалтын тайлан нь бондын хөрөнгийг эрх бүхий төсөл, хөрөнгөд хэрхэн хуваарилсныг баталгаажуулдаг;
    - » Шалгуур үзүүлэлтийн тайлан нь холбогдох салбарын ангилал зүйн дагуу төсөл, хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэлийг баталгаажуулдаг;
    - » Нөлөөллийн тайлан нь төсөл, хөрөнгийн хүлээгдэж буй эсвэл бодит нөлөөллийг тусгасан хэмжүүр эсвэл шалгуур үзүүлэлтүүдийг тодруулдаг.
  - Дээр дурдсан энэхүү тайланг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэх ба бондын үлдэгдэлтэй байх хугацаандаа жил бүр хөрөнгө оруулагчид хүргүүлэх ёстой.
  - Хуваарилалтын тайланд дараах зүйлийг багтаасан байх ёстой:
    - » бондын орлого ногоон бондын танилцуулгад тусгагдсан төслүүдэд хуваарилагдсан эсэх, тэдгээр нь Уур амьсгалын бондын стандарттай нийцэж байгааг баталгаажуулах;
    - » бондын уур амьсгалтай холбоотой зорилгын талаарх мэдэгдэл;
    - » цэвэр орлогыг хуваарилсан төсөл, хөрөнгийн жагсаалт;
    - » төсөл, хөрөнгөд хуваарилсан мөнгөн дүн;
    - » төсөл, хөрөнгийн мэдээллийг газарзүйн байршлаар мэдээлэх.
  - Шалгуур үзүүлэлтийн тайланд дараах агуулгыг багтаасан байх ёстой:
    - » санхүүжилт авсан төсөл, хөрөнгө нь гэрчилгээ авах үед тавигдаж байсан шаардлагыг хангасан хэвээр байгааг баталгаажуулсан талаар;
    - » төсөл, хөрөнгийн гүйцэтгэлийн талаарх мэдээлэл;
    - » салбарын шалгуурыг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг санхүүжүүлсэн тохиолдолд хуваарилагдсан орлого, түүний ашиглалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэх.
  - Нөлөөллийн тайлан нь дараах агуулгыг багтаасан байх ёстой:
    - » бондын уур амьсгалтай холбоотой зорилтуудын талаар нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн хүлээгдэж буй эсвэл бодит үр дүн, нөлөө;
    - » төслийн үр дүн, нөлөөллийн гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтүүд, боломжтой бол гүйцэтгэлийн тоон үзүүлэлтүүд;
    - » гүйцэтгэлийн үзүүлэлт, хэмжигдэхүүнийг тооцоолох арга.
  - Шинэчлэгдсэн тайланд тодорхой төсөл, хөрөнгийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байгаа тохиолдолд яагаад хязгаарлагдмал байгаа талаар тайлбар оруулах.
  - Бонд гаргагч нь шинэчилсэн тайланг дэмжих аливаа баталгаажуулалтын тайлан эсвэл бусад холбогдох материалыг олон нийтэд эсвэл бонд эзэмшигчдэд нээлттэй мэдээлэх ёстой.



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

## Цуврал №43

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

### Хадгаламжийн сертификат гэж юу вэ?



**Хадгаламжийн сертификат (ХС)** нь ердийн хадгаламжаас илүү өндөр хүү санал болгодог тодорхой хугацаатай нэрлэсэн үнэ бүхий хадгаламжаар баталгаажсан үнэт цаас юм.

### Хадгаламжийн сертификат ямар онцлогтой вэ?



**Тодорхой хугацаатай:**

Богино хугацаат – 3 сар, 6 сар, 1 жил  
Урт хугацаат – 2 жил, 5 жил



**Илүү өндөр хүүтэй:**

Бусад хадгаламжийн бүтээгдэхүүнээс илүү өндөр хүүтэй байдаг.



**Баталгаатай :**

Банк болон төрийн хадгаламжийн даатгалын байгууллагаар (зарим төрлийг) баталгаажуулдаг.



**Хатуу нөхцөлтэй:**

Хадгаламжийн хугацааны дундуур цуцлах болон хугацаа дуусахад сунгах боломжгүй.



Төрлөөс хамааран хадгалуулсан хөрөнгө үнэт цаасаар баталгаажиж байгаа тул бусад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, барьцаалах боломжтой.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**Цуврал №43**

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

**Уламжлалт  
хадгаламжийн  
сертификат**

банкнаас гаргадаг,  
тодорхой хугацаа,  
хүүгийн нөхцөлтэй  
хадгаламжийн  
гэрчилгээ юм.



**Хадгаламжийн  
сертификатын үндсэн  
төрөл**

**Арилждаг  
хадгаламжийн  
сертификат**

хоёрдогч зах зээл дээр  
худалдаалах,  
шилжүүлэх боломжтой  
үнэт цаасны төрөл юм.

**Уламжлалт хадгаламжийн  
сертификат**



Эзэмшигч нь зөвхөн  
гаргасан банкнаас мөнгөө  
буцааж авна;



Хөрвөх чадвар бага;



Тогтмол хүүтэй;



Эрсдэл багатай.

**Арилждаг хадгаламжийн  
сертификат**



Зах зээл дээр худалдаж,  
бусдад шилжүүлэх  
боломжтой;



Хөрвөх чадвар өндөр.  
Арилжааны зах зээл дээр  
худалдаалагддаг;



Ихэвчлэн өндөр хүүтэй, зах  
зээлийн нөхцлөөс хамаарч  
өөрчлөгдөж болно;



Эрсдэл арай өндөр. Зах  
зээлийн үнээс хамаарч  
үнэгүйдэх боломжтой.

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжих боломжийг тусгасан.



**ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ХЯТАДЫН ЖИЖИГЛЭНГИЙН БОРЛУУЛАЛТ 10 ДУГААР САРД ЭРЧИМТЭЙ ӨСӨЖ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БУУРЛАА.



11 дүгээр сарын 15 – Хятад улс 10 дугаар сард жижиглэнгийн борлуулалт эрчимтэй өсөж, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт буурсан тухай мэдээлсэн нь тус улсын сүүлийн үеийн бодлого нь эдийн засгийн зарим салбарыг дэмжихэд аль хэдийн нөлөөлсөн болохыг харуулж байна.

Үндэсний статистикийн товчооны тайланд дурдсанаар жижиглэнгийн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 4.8 хувиар өссөн нь Reuters-ийн санал асуулгаар таамаглаж байсан 3.8 хувийг давсан үзүүлэлт юм.

Аж үйлдвэрлэл жилийн өмнөхөөс 5.3 хувиар өссөн нь 5.6 хувийн өсөлтийн хүлээлтэд хүрээгүй байна. Харин үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өссөн нь 3.5 хувиар төсөөлж байснаас бага байна.

Эхний 10 сарын байдлаар үл хөдлөх хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар буурсан нь тус улсын үл хөдлөх хөрөнгийн уналт улам эрчимжсээр байгааг харуулж байна.

Үндэсний статистикийн товчооны хэвлэлийн төлөөлөгч Фу Линхуй баасан гарагт хийсэн хэвлэлийн бага хурал дээр Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн уналтыг зогсоох амлалтаа дахин илэрхийлсэн.


Ойрын 12–18 сарын хугацаанд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт тогтворжиж бага зэрэг сэргэнэ гэж JLL-ийн Их

Хятадын судалгааны албаны ахлах эдийн засагч Брюс Панг хэллээ.

Оны эхний 10 сард борлуулсан шинэ үл хөдлөх хөрөнгийн үнэ 20.9 хувиар буурсан нь 9 дүгээр сарын байдлаар 22.7 хувиар буурсан үзүүлэлттэй харьцуулахад сайжирсан үзүүлэлт юм.

Эх сурвалж: [www.cnbc.com](http://www.cnbc.com)

### BLACKWELL AI ЧИП ХЭТ ХАЛСАН ТУХАЙ МЭДЭЭЛСНИЙ ДАРАА NVIDIA-ИЙН ХУВЬЦАА УНАЛАА.



Хамгийн сүүлийн үеийн Blackwell AI чипийн хэт их халалтын асуудлыг онцолсон мэдээ гарсны дараа Nvidia-ийн хувьцаа даваа гарагт 3.4 хувиар буурлаа.

Энэ нь тус компанийн бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал гарсан анхны тохиолдол биш юм. Өнгөрсөн 8 дугаар сард дизайны алдаатай ажиллаж байна гэж мэдээлсэн.

Мэдээллийн дараа Dell Technologies-ийн гүйцэтгэх захирал Майкл Делл, компанийн PowerEdge системийн нэг хэсэг болгон Nvidia-ийн Blackwell серверүүдийг аль хэдийн нийлүүлж, ашиглаж эхэлсэн гэж мэдэгджээ. Эдгээр серверүүд нь хиймэл оюун ухааны тооцоололд зориулагдсан өндөр хүчин чадалтай төхөөрөмжүүд юм.

Nvidia-ийн хувьцааны ханш буурсан хэдий ч өнгөрсөн жилийнхээс ойролцоогоор 186 хувиар өссөн. Уг өсөлт нь дэлхийн томоохон компаниудын нэг болох Apple-ийг давж гарсан.

Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

## ЯПОНЫ ЭКСПОРТ ХЯТАДЫН ЧИПИЙН ЭРЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛСНЭЭР СЭРГЭЖ БАЙГАА Ч ТРАМПЫН ТАРИФЫН ЭРСДЭЛ НЭМЭГДСЭЭР БАЙНА.



ТОКИО, 11 дүгээр сарын 20 (Ройтерс) – 10 дугаар сард Японы экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өсөж, Ройтерс агентлагийн 2.2 хувийн өсөлтийн таамаглалыг давлаа. Энэ өсөлт нь Хятад дахь чип үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн эрэлт нэмэгдсэнтэй холбоотой гэж шинжээчид үзэж байна. Хятад руу хийсэн экспорт 1.5 хувиар өссөн нь чип тоног төхөөрөмжийн эрэлт өндөр байгааг харуулж байна. Харин АНУ руу хийсэн экспорт 6.2 хувиар буурсан нь Японы автомашины экспортын хэмжээний бууралтаас шалтгаалж байна. Автомашины

тээвэрлэлт суларч, АНУ–д автомашины экспортын бууралт Японы нийт экспортын өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Японы гадаад худалдааны гол асуудал нь АНУ–ын худалдааны бодлого болоод байна. АНУ–ын Ерөнхийлөгчөөр Дональд Трамп сонгогдсоны дараа шинэ, өндөр тарифуудын нөлөөгөөр олон улсын худалдаанд саад тотгор үүсэх эрсдэлтэй гэж япон бизнес эрхлэгчид таамаглаж байна. Mizuho Securities–ийн ахлах эдийн засагч Шунсуке Кобаяши АНУ бүх импортын бараа бүтээгдэхүүнд 10 хувийн татвар ногдуулбал Японы дотоодын нийт бүтээгдэхүүн 0.13 хувиар буурах магадлалтай гэж тооцоолжээ. Мөн Хятадад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд 60 хувийн татвар ногдуулахад ч Японы эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэдгийг онцолсон байна.

Гэхдээ эдийн засагчид Хятадад татвар нэмэгдүүлэх нь Японы АНУ–д эзлэх зах зээлийн хувийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Энэ нь Японы экспортын нийт хэмжээнд чухал нөлөө үзүүлж болох юм. Түүнчлэн Япон улсад дотоодын эрэлт нэмэгдэх шинж тэмдэг ажиглагдаж байна. 3 дугаар улирлын ДНБ–ий мэдээллээс харахад, цалингийн өсөлтөөс шалтгаалан хувийн хэрэглээ өсөж, эдийн засаг нь таамагласнаас илүү сайжирсан байна.

Японы худалдааны статистикаас харахад, импорт 10 дугаар сард 0.4 хувиар өсөж, зах зээлийн таамаглалыг давлаа. Энэ хугацаанд Японы гадаад худалдааны алдагдал 461.2 тэрбум иен буюу 2.98 тэрбум ам.долларт хүрчээ.

*Эх сурвалж: www.reuters.com*

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 11 дугаар сарын 30-ны өдөр

S&P 500 (^GSPC)

**6,034.91** -17.94 (-0.30%)



Nikkei 225 (^N225)

**38,197.27** +298.15 (+0.77%)



FTSE 100 (^FTSE)

**8,285.77** +36.78 (+0.45%)



NASDAQ Composite (^IXIC)

**19,687.72** +48.58 (+0.26%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

